

“ Музейн үйлчилгээ ба аюулгүй байдал”

Музей судлалын мэргэжил –арга зүйн төв ба аюулгүй байдал үйлчилгээний албаны сургалт

2015.04.15

Хичээлийн сэдэв: Соёлын өвийн хадгалалт хамгаалалт ба музейн аюулгүй байдал

1. Аюулгүй байдал гэж юу вэ?
2. Болзошгүй аюулын төрөл
3. Аюул гамшгийн үр дагавар
4. Байгууллагын түвшний хамгаалалт

- Эрсдлийн дүн шинжилгээнээс эрсдлийг бууруулах
- Музейн хамгаалалтын тогтолцоо

Музейн аюулгүй байдал гэж

- Ажилтнууд, үзэгчид, цуглуулга, бусад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө болон нэр хүндээ хамгаалах үндсэн зорилгоо хэрэгжүүлэх музейн чадавхи
- Учирч болзошгүй аюулын түвшинг тодорхой боломжит түвшинд барих музейн чадварыг хэлнэ.

Юуг юунаас хэрхэн хамгаалах вэ?

Музейн барилгын орчин тойрон учирч болзошгүй болзошгүй аюулын төрөл:

1. Хууль бус үйлдэл
2. Аваар осол
3. Барилга дотор гарч болзошгүй гэнэтийн аваар осол

ХУУЛЬ БУС ҮЙЛДЭЛ

- Үзэгчид ба ажилтнууд хулгай хийх
- Гаднаас хулгай орох
- Эвдэн сүйтгэх
- Үзэгчээс зохисгүй авир гаргах, хүч хэрэглэх
- Санаатай галдан шатаах
- Зөвшөөрөлгүй, бүртгүүлэлгүй нэвтрэх
- Зэвсэглэсэн этгээд

АВААР ОСОЛ

- Ажилтан ба үзэгч бэртэх гэмтэх
- Химийн бодис алдагдсанаас үүдэх осол
- Агааржуулагчийн гэмтэл

- Цахилгаан, хий, дулаан, усны доголдол
- Аюулгүйн дохиоллын систем ажиллагаагүй болох
- Аюулгүйн холбооны систем ажиллагаагүй болох

БАРИЛГА ДОТОР ГАРЧ БОЛЗОШГҮЙ ГЭНЭТИЙН АВААР ОСОЛ

- Гал түймэр
- Усны шугам болон дулааны системээс ус алдах
- Хэт халах эсвэл хүйтрэх
- Гэрлийн хэт халалт

Хулгай

- Хулгайчдын анхаарлыг урлагийн бүтээл, үнэт металлаар хийгдсэн үзмэр татна
- Үзэл суртал, шашны бэлгэдэл
- Үнэ өртөгийн хувьд үнэтэй бус ч өөр шалтгаанаар үнэ цэнэтэй.

Байгууллагын түвшний аюулгүй байдал

- Олон нийтэд цуглуулгаа үзүүлэх
- Үзэгчдэд ая тухтай үйлчилгээ үзүүлэх
- Ажилтнууд, үзэгчид, музейн барилга дотор буй хүмүүсийн эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хангах арга хэмжээ
- Үзмэрийн аюулгүй байдлыг хангах
- Цуглуулгатай зөв харьцах
- Музейн захирал эрсдлийн шинжилгээнд үндэслэн аюулгүй байдлын бодлогыг тодорхойлно.

Музейн захирлын зөвшөөрлөөр аюулгүй байдлын менежер томилогдоно. Менежерийн ажлын байрны тодорхойлолтод байгууллагын эзэмшиж хариуцаж байгаа бүх байр барилга ба үзүүлэлэг, сан хөмрөгт хадгалагдаж байгаа бүх зүйлд эрсдлийн шинжилгээ хийх үүрэг тусгагдана.

Бүх ажиллагсад ялангуяа менежер, нэгж албаны удирдлагууд аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх сайжруулах үүрэгтэй.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Музейг удирдах байгууллага ба удирдлага аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.

Музейн удирдлага юуны түрүүнд эрсдэлийн шинжилгээгээр байгууллагад бүхэлд нь болон хэсэгт нь (ажиллагсад, үзэгчид, сан хөмрөг бусад биет ба биет бус эд зүйлс ба музейн нэр хүнд) заналхийлж байгаа аюул заналыг тодорхойлно.

Аюулгүй байдлын арга хэмжээ

- Эрсдлийн менежментийн баг бүрдүүлнэ
- Эрсдэлийн үнэлгээний шинжилгээний үр дүнг анхаарна
- Эрсдэл үүсэх магадлалыг тогтоож, захиргаанд мэдэгдэж, ажилтнуудыг бэлтгэнэ.
- Гарах үр дагавар ба гэмтлийг үнэлнэ.

Эрсдэлийг арилгах зорилготой аюулгүй байдлын арга хэмжээ

1. Механик саад
2. Харуулын зохион байгуулалт
3. Ажилтнууд ба үзэгчдын биеэ авч явах талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээ
4. Барилгын дотор тал ба үзүүлэлтийн зохиомжтой хослуулсан зохион байгуулалтын арга хэмжээ
5. Халдлага илрүүлэх систем (IDS)
6. Галын дохиоллын систем (FAS)
7. Унтраах систем
8. Нэвтрэх хяналтын систем (ACS)
9. Хяналтын дэлгэц (CCTV)
10. Дотоод хяналтын ба онцгой байдлын талаар тайлагнах систем
11. Эрсдэлтэй физик тоон үзүүлэлтүүдийг зохицуулах ба авах арга хэмжээ (температур, чийгшил, гэрлийн хүчин чадал ба хэт ягаан туяаны цацраг)
12. Техникийн хэмжигдэхүүний талаарх арга хэмжээ (ус, хий, тоосонцор)
13. Дотоод ба гаднах гэрэлтүүлэг
14. Агаар мандлын хүчин зүйлийн нөлөөгөр үүсэх хэт хүчдэлийг эсэргүүцэх хамгаалалтын систем.
15. Дотоодын хяналтын төв (хянах өрөө)
16. Хяналтын төвөөс холбогдох хамгаалалтын байгууллага руу дохиолол дамжуулагч систем
17. Соёлын объектод бичгээр ба дүрсээр баримтжуулах систем
18. Онцгой байдлыг шийдвэрлэх систем (онцгой байдлын төлөвлөгөө)
19. Үндэсний, олон улсын байгууллага агентлагуудтай хамтран ажиллах
20. Хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах
21. Байгалийн гамшгийн анхааруулдаг улсын хэмжээний системтэй хамтран ажиллах
22. Гамшгийн төлөвлөгөө-хадгалалт ба сэргээн засварлалт

1. Механик саад

Механик саад гэж барилгын бөх бат хана, цоож, галд тэсвэртэй хаалга, хаалт, хашаа, дохиоллын шил, хорго, сейф, хамгаалалттай өрөөг хэлнэ. Эдгээр нь сан хөмрөгийг эвдрэл гэмтлээс хамгаалах үндсэн хэрэгсэл болно; бусад систем нь дагалдах систем болно. Бөх бат хаалга, тохирсон цоож тэдгээрийг зохистой ашиглах нь музейн хамгаалалтын системийн чухал хэрэгсэл юм.

Хамгаалалттай газар халдлага орсон тухай мэдээлэл хүрсэний дараа хулгайч нэг түүнээс дээш тооны механик саадыг давахын тулд нилээд хугацаа зарцуулах ёстой.

2. Хамгаалагч нарын зохион байгуулалтын систем

Музейн удирдлага хамгаалагч нарын ажиллах журмыг тогтооно. Хамгаалагч нарын тоо нь барилга, үзүүллэгийн танхимын хэмжээ, онцлог ба үзэгчдийн тоо, цуглуулгын үнэ цэнээс хамаарна. Хяналтын теле камер ба электрон дохиоллын систем зэрэг нь хамгаалалтад чухал үүрэгтэй боловч хамгаалалтын ажилтны үүргийг орлож чадахгүй.

Хамгаалалтын ажилтан хамгаалалтын асуудал үүссэн нөхцөлд менежментийн шат дараалсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх бөгөөд хүн бүр юу хийх, хэнд мэдээлэх зэргийг мэдсэн байх ёстой.

Музей, соёлын өвтэй холбоотой хэн бүхэн соёлын өвийн талаар онцгой үүргийг хүндлэн ухамсарлаж хамгаалалтын заавар журмыг сахин мөрдөх ёстой. Аюулгүй байдлыг хангах хамгаалалтын төлөвлөгөө нь музейн дотоод зохион байгуулалт ба үйл ажиллагаатай уялдаатай байна. Ж: үзмэрийг хөдөлгөх, түр үзэсгэлэнд илгээхэд аюулгүй байдлыг хангах хэрэгтэй.

Аюулгүй байдлыг хангахад оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал.
Гинжийн нэг хэлхээ сул бол гинж нийтдээ сул гэсэн дүрэм байдаг.

Хорлон сүйтгэх ажиллагаа -вандализмаас урьдчилан сэргийлэх хянах жагсаалт, арга хэмжээ

- Үзмэр өөрөө вандализмын өдөөгч болдог
- Шашны болон улс төрийн асуудлын дохио болох
- Үзэгчид тасалбар худалдан авч музейд орохдоо музейн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, музей тавих шаардлагаа ойлгомжтой болгох
- Бие даасан болон бүлэг үзэгчдийн зан авирыг ажиглаж байх
- Үзэгчдээ боловсруулах: Яагаад үзмэрийг барьж үзэж болохгүй вэ гэдгийг тайлбарлан ойлгуулах
- Цүнх, таяг, шилтэй шингэн зүйлс, бусад зүйлс гар тээшээ өлгүүрийн өрөөнд үлдээж орох
- Шаардлагатай бол үзэгчдийг 2-оос дээш хүн дагаж ажиглах
- Шөнөдөө гэрэлтүүлэгтэй болгох
- Харуулын ажилтнуудыг сэжигтэй зан үйлийг ялгаж танихад сургах
- Харуулууд вандализмын үйлдэл тохиолдоход зохих журмын дагуу харьцаж сурах
- (Гэмт хэрэгтнээс үзмэрийг хамгаалах)
- Боломжтой бол хяналтын дэлгэц CCTV суурилуулах, журмыг дагаж мөрдөх

- Боломжтой бол дохиолол хамгаалалтын систем суурилуулж, үзмэрийн танхим, хоргонуудад дохиолол суурилуулах

Вандализмын үед авах арга хэмжээ

- Гэмтсэн үзмэрийг тэр хэвээр нь үлдээ
- Химийн бодис хэрэглэсэн бол өөрийн аюулгүй байдлаа ханга
- Гэмтсэн үзмэрт бүү хүр, хүрсэн тохиолдолд гэмтэл тэлэх тул анхаар
- Цагдаа нар шалгах тул ул мөрийг бүү арч
- Гэмт этгээд музейн дотор байгаа бол чимээ шуугиан гаргахгүй байх. Учир нь уг этгээд нэмж эд өлөг гэмтээж болзошгүй
- Хүмүүс эд өлгөөс илүү чухал тул болзошгүй аливаа эрсдэлээс зайлсхий

Гал түймэр гарвал:

- 1 Аюултай газраас үзэгчдийг (мөн ажиллагсдыг) гаргах
2. Боломжтой бол хаалгаа хааж галыг хязгаарлах
3. Аюулгүйн хяналтын өрөө /Галын алба ... тай [утасны дугаарт залгах] холбоо барих/эсвэл хамгийн ойрын автомат дохиоллын станцад мэдээлэх.

Хөдөлгөөнт холбоо ба утас ашиглан дараах мэдээллийг өгнө. Үүнд:

- а. Гал түймэр гарсан газрын байрлал
- б. Галыг таслан зогсоох боломж
- в. Таны нэр

Аюулгүйн хяналтын өрөө /Галын алба утсаа таслахаас өмнө утсаа бүү тасал.

- 4.Найдвартай гүйцэтгэж чадна гэж үзвэл багаахан галыг галын хороор унтраахыг оролдох.
- 5.Галыг унтраах боломжгүй бол тухайн газраас холдох. Нүүлгэн шилжүүлэх цугларалтын газар очих.

Нэмэлт мэдээлэл:

- 6.Хэрэв боломжтой бол галын ойролцоох цахилгаан төхөөрөмжийг салгах. Залгуурыг салгах эсвэл гал хамгаалагч ба цахилгааны эх үүсвэрийг салгах.
7. Таны болон гарц хоёрын дундуур гал орж ирэх ослыг бүү гаргах.
8. Галын утаа, үнэр хортой гэдгийг санаж байх.
9. Маш чухал эсвэл зугтахаас бусад тохиолдолд цонхыг бүү хагал, учир нь хүчилтөрөгч галыг ихэсгэдэг. Хаалга онгойлгохоос өмнө дээд талд нь хүрч үзэх. Хэрэв хаалга халуун байх юм уу цаанаас нь утаа харагдаж байвал хэзээ ч бүү онгойлго.
10. Цахилгаан шат бүү ашигла.

11. Хэрэв та зугатаж байгаа бол хувийн жижиг зүйлсээ (түлхүүр, түрийвч г.м.) ав, гэхдээ эд зүйлсээ аврахын тулд хэзээ ч өөрийгөө эрсдэлд бүү оруул. Ардаа ямар ч хамаагүй том эсвэл хүнд зүйл орхиж галыг удаашруулахыг хичээ. Хэрэв та гарч байгаа сүүлчийн хүн бол хаалгаа хаа, гэхдээ түгжиж болохгүй.

12. Байгаа газар чинь утаатай байвал утаа, халуунаас аль болох доош түвшинд бай. Шаардлагатай бол хэвтэж мөлх.

13. Хэрэв таны эсвэл хэн нэгний хувцас шатаж байвал хэвтэж өнхөрч галыг унтраа.

14. Галын багийнхан ба хамгаалалтынхан зөвшөөрөхөөс нааш осол гарсан газар руу буцаж орж болохгүй.

15. Та өрөөндөө түгжигдсэн бол:

а. Ямар ч аргаар хамаагүй утсаар тусламж дууд: гар утас эсвэл суурин утсаар.

б. Утаа оруулахгүйн тулд хаалганы доогуур даавуун материал чигж.

в. Гал болон таны хооронд байгаа аль болох олон хаалгыг хаа.

г. Цонх түгжээгүй, танд агаар хэрэгтэй байгаа бол цонхоо онгойлго. Харин цонхыг бүү хагал, учир нь дараа нь түүнийг хаах хэрэг гарч болно.

Аливаа гал түймрийн талаар бага хэмжээний унтраах боломжтой гал байсан ч аюулгүйн албанд яаралтай мэдэгдэх бөгөөд энэ нь галын байгууллагад мэдээлэл хүргэх боломж олгоно.

ДҮГНЭЛТ

- Музейн хамгаалалтын систем нь зогсолтгүй үргэлжлэх үйл явц юм.
- Хамгаалалтын системийн агуулга нь олон салбарын цогц ойлголтуудыг нэгтгэсэн, музейн удирдлага, бүх ажилтнуудын оролцоог шаарддаг.
- Хамгаалалтын систем нь зохион байгуулалт, барилга байгууламж, электрон хангамжийн аюулгүй байдлын хэм хэмжээг нягт хослуулсан байх ёстой.
- Хамгаалалтын систем нь эрсдлээс хамгаалах, түүнийг бууруулах, гамшигт өртсөн эд зүйлийг үнэлэх зэрэг ажлыг эрхэлж буй хүн бүхэнд хамаатай чухал ажил юм.

Аюулгүй байдлыг хангах нь хүн бүрийн үйл хэрэг мөн

Pavel Jirásek багшийн хичээлээс товчлон бэлтгэв.

Д.Бумаа Дэд проф, Ph.D

МҮМ-н Музей судлал, мэргэжил арга зүйн төвийн дарга

pavel.jirasek@gmail.com